



**“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК”
ОНӨТҮГ-ЫН 2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**УЛААНБААТАР ХОТ
2021 ОН**

**“НАЛАЙХЫН БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛ,
ТЕХНОЛОГИЙН ПАРК” ОНӨТҮГазар**

2021 оны 12 дүгээр сарын 15-ны өдөр

Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хүрээнд тус парк 2021 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

Удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр:

Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан ажлууд төлөвлөгөөний дагуу хугацаандаа хэрэгжиж байна. Энэ хугацаанд:

- Нийслэлийн онцгой комиссын хурлын тэмдэглэл – 5
- Нийслэлийн засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл – 3
- Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын даргын захирамж - 1
- Төрийн болон бусад байгууллагаас нийт 194 албан бичиг ирснээс хариутай албан бичиг нь 89 байж хариуг хугацаанд нь хүргүүлсэн. Байгууллагаас бусад байгууллага, аж ахуй нэгжүүдэд нийт 190 албан бичиг явуулсан.

**НЭГ.НИЙСЛЭЛИЙН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2021 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН
ЧИГЛЭЛИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР:**

1.1. Цэвэрлэх байгууламж барих ажлыг эхлүүлэх.

- Цэвэрлэх байгууламжийн барилга угсралтын ажлын Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр БХБЯ-д танилцуулагдаж, судлагдсаны дагуу “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн нэгжээр дамжин хэрэгжиж буй төслүүдийн хүрээнд хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг “Европын сэргэн босголт, хөгжлийн банк”-ны санхүүжилтээр санхүүжүүлэхээр шийдвэрлэж, уг байгууламжийн гадна цахилгаан хангамжийн ажлын зураг төслийг гүйцэтгэгч байгууллага болох “ББСМО” ХХК-аар хийж гүйцэтгүүлсэн. Хөрөнгө оруулалтын асуудлыг Сангийн ямаар дамжуулан “Европын сэргэн босголт, хөгжлийн банк”-тай хэлэлцээрийн шатанд явагдаж байна.

1.2. Барилгын материалын бөөний болон жижиглэн худалдааны төвийн техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлүүлж, ажлыг эхлүүлэх.

- Нийслэлийн Засаг даргын 2020 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/1081 тоот шийдвэрийг үндэслэн барилгын материалын бөөний болон жижиглэн худалдааны төв байгуулах 60 га газрын давхцалыг арилгуулан авсан.
- Төлөвлөлт хийх эхний ээлжийн ерөнхий төлөвлөгөө, судалгаа хийгдсэн бөгөөд Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газартай хамтран ТЭЗҮ, ХЕТ боловсруулах 201 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг татах ажлууд хийгдэж байна.

1.3. Паркийн дулааны станцын хөрөнгө оруулалтыг татах ажлыг зохион байгуулна.

- Дулааны станцын барилга угсралтын ажлын Хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлүүлэхээр БХБЯ-д танилцуулагдаж, судлагдсаны дагуу “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн нэгжээр дамжин хэрэгжиж буй төслүүдийн хүрээнд хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг “Европын сэргэн босголт, хөгжлийн банк”-ны санхүүжилтээр санхүүжүүлэхээр шийдвэрлэж, уг байгууламжийн гадна цахилгаан хангамжийн ажлын зураг төслийг хийлгэхээр ажиллаж байна. Үүний дагуу ЭХЯ-аас гадна цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийг шийдвэрлүүлэхээр холбогдох баримт бичгийг цахимаар хүргүүлээд байна.

ХОЁР. БАЙГУУЛЛАГЫН ДҮРМЭЭР ХҮЛЭЭСЭН
ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР:

- 2.1. 110/35/10 кВ-ын үндсэн цахилгаан хангамжийн ажилд хяналт тавин ажиллах.
- 2х16 мВА чадалтай 110/10 кВ-ын “Налайх парк” дэд станцын барилга угсралт, монтажийн ажил дууссан ба 110, 10 кВ-ын шугам сүлжээнд холбох холболт, туршилт тохируулгын ажил үлдээд байна. 110 кВ-ын ЦДАШ-ын угсралтын ажил эхлээгүй бөгөөд 4 ширхэг хаалттай хуваарилах байгууламжийн барилга угсралт, кабель шугамын суваг шуудууны ажлууд хийгдсэн. Уг ажил 20%-ийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд ирэх онд үргэлжлүүлэн гүйцэтгүүлэх, хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлүүлэх холбогдох яам, нийслэлийн газруудад хүсэлт гаргаад байна.
- 2.2. Үндсэн цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийн хугацааг сунгах.
- Үндсэн цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийн хугацааг сунгуулах баримт бичгийг бүрдүүлэн ЭХЯ-д хүргүүлснээр тус яамнаас 2021.01.05-ны өдрийн 65/2019/252 тоот техникийн нөхцөлийг ирүүлсэн болно.
- 2.3. Шинээр үйлдвэр байгуулах аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллах.
- 2021 онд нийт 18 аж ахуйн нэгж паркт байрших хүсэлт ирүүлсэн ба тэдгээрийн төсөл, байгаль орчинд ээлтэй, хөрөнгө оруулалтын тогтвортой байдал, шинэ технологийн талаарх мэдээллийг судалж дүгнэлтийг гарган 15 аж ахуйн нэгжтэй шинээр хамтран ажиллах гэрээ байгуулсан байна.
- 2.4. Гэрээний дагуу үйлдвэрүүдийн бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлэх.
- Паркийн 120 га газар дээр нийт 45 аж ахуйн нэгж үйл ажиллагаа эхлэх гэрээ байгуулан ажиллаж байгаа бөгөөд 2021 оны байдлаар “Пийс стийл групп” ХХК нь 138,091 ширхэг, 2,761,820тн бүтээгдэхүүн үйлдвэрлэн гаргаж, үүнээс 135,300 ширхэг, 2,696,280тн бүтээгдэхүүн экспортод гаргаад байна.
 - 8 аж ахуйн нэгж үйлдвэрийн барилга байгууламжаа барихад бэлэн болсон бөгөөд бичиг баримтын бүрдлийг хангах ажлууд хийгдэж байна.
- 2.5. Үйл ажиллагаа явуулах гэрээ байгуулсан үйлдвэрүүдийн ажлыг дүгнэх.
- Хамтран ажиллах гэрээнд тусгасан үндсэн 43 эрх, үүргийн дагуу үйлдвэрүүдийн гэрээг 2021 оны 09 дүгээр сарын 02-нд дүгнэж, дүгнэлтийг үйлдвэрүүдэд хүргүүлсэн. Уг дүгнэлтийн хүрээнд авч хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудад үйлдвэр хариуцсан мэргэжилтнүүд хяналт тавьж ажиллаж байгаа бөгөөд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй 10 аж ахуйн нэгжтэй хамтран ажиллах гэрээ цуцалж, 10 аж ахуй нэгжид хугацаатай үүрэг даалгавар хүргүүлсэн.
- 2.6. Паркт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд дэмжлэг үзүүлэх.
- Гэрээ байгуулсан аж ахуйн нэгжүүдэд Архитектур төлөвлөлтийн даалгавар, Байгаль орчны нарийвчилсан үнэлгээ, цахилгааны техникийн нөхцөл, холбооны техникийн

нөхцөл зэрэг бүрдүүлэх шаардлагатай бичиг баримтуудаа холбогдох шатны байгууллагаас авахад нь зөвлөгөө, дэмжлэг үзүүлж ажиллаж байна.

2.7. Паркт байрших үйлдвэрүүдийн цахилгаан хангамжийн асуудлыг шийдвэрлэх.

- Бүтээн байгуулалтаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийг 630 кВ-ын дэд станцаас цахилгаан эрчим хүчээр хангаж байгаа бөгөөд үйлдвэр тус бүртэй цахилгаан эрчим хүчээр хангах гэрээ байгуулан ажиллаж байна.

2.8. Паркт байрших үйлдвэрүүдийн усан хангамжийн асуудлыг шийдвэрлэх.

- Паркийн хэрэгцээг бүрэн хангах 8,96 л/сек хүчин чадал бүхий гүний худаг хэвийн үйл ажиллагаатай байгаа бөгөөд бүтээн байгуулалтаа хийж буй аж ахуйн нэгжүүдтэй зөөврийн цэвэр усаар хангах гэрээ байгуулан ажиллаж байна.

2.9. Паркт байрших үйлдвэрүүдийн хог хаягдлыг ангилал, зөөж тээвэрлэх асуудлыг шийдвэрлэх.

- Налайх дүүргийн тохижилт үйлчилгээний хэлтэс, парк, аж ахуйн нэгжүүдтэй хог хаягдлын ангилж, тээвэрлэх гурвалсан гэрээ байгуулан Налайх дүүргийн төвлөрсөн хогийн цэгт хог хаягдлыг тээвэрлэж байна.

2.10. Паркийн усан хангамжийн ажлын хөрөнгө оруулалтыг татах ажлыг зохион байгуулах.

- Цэвэр усны 400м³ багтаамжтай 2 усан сан, техник галын 200м³ багтаамжтай 2 усан сан, ус түгээх шугам сүлжээ байгуулах хөрөнгө оруулалт татах ажлын хүрээнд ажлын зураг, төсөвт өртгийн мэдээлэл зэрэг шаардлагатай материалуудыг 2022 оны Улсын төсөв болон Концессын зүйлийн жагсаалтанд оруулахаар БХБЯам, Үндэсний Хөгжлийн Газар, Хөгжлийн банк зэрэг байгууллагуудад албан бичгээр хүсэлт гарган хүргүүлсэн.

2.11. Паркийн салбар төмөр замын хөрөнгө оруулалтыг татах ажлыг зохион байгуулах.

- Салбар төмөр замын хөрөнгө оруулалт татах ажлын хүрээнд ажлын зураг, төсөвт өртгийн мэдээлэл зэрэг шаардлагатай материалуудыг 2022 оны Улсын төсөв болон Концессын зүйлийн жагсаалтанд оруулахаар Зам Тээвэр Хөгжлийн Яам, Үндэсний Хөгжлийн Газар, Хөгжлийн банк зэрэг байгууллагуудад албан бичгээр хүсэлт гарган хүргүүлсэн.

2.12. Паркийн өргөтгөл 130 га талбайд хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө хийх.

- Паркийн өргөтгөл 130 га газрыг Нийслэлийн Засаг даргын 2019.05.30-ны өдрийн А/526 тоот захирамжаар авсан.
- Барилга хот байгуулалтын сайдын 2020.09.07-ны өдрийн 169 дугаар тушаалын дагуу паркийн өргөтгөл 130 га газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалт явагдаж “Өрх” ХХК 2021.01.28-ны өдөр 2021/47 дугаар гэрээ байгуулан ажиллаж гүйцэтгэл дууссан ба мэргэжлийн зөвлөлийн дүгнэлт болон магадлал хийлгэх ажлууд хийгдэж байна.
- ХЕТ-ний нийт ажлын гүйцэтгэл 95%-тай явж байна.

2.13. Паркийн өргөтгөл 130 га талбайд мастер төлөвлөгөө боловсруулах.

- Барилга хот байгуулалтын сайдын 2020.09.07-ны өдрийн 169 дугаар тушаалын дагуу паркийн өргөтгөл 130 га газрын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулагдаж байгаа бөгөөд түүнд нийцсэн мастер төлөвлөгөө боловсруулах 20 сая төгрөгийн төсвийг Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх зураг төслийн саналд хүргүүлсэн.

2.14. 120 га талбайд техник технологийн түвшний үнэлгээ хийлгэх.

- Үйлдвэрлэл, технологийн паркийн эрх зүйн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.3 дахь хэсгийн дагуу техник технологийн түвшний үнэлгээг боловсруулах 45 сая төгрөгийн төсвийг Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2022 онд хэрэгжүүлэх зураг төслийн саналд хүргүүлсэн.

2.15. 100 айл ажлын хэсгээс гаргасан барилгын материалын үйлдвэрүүдийг шилжүүлэх төлөвлөгөөнд үндэслэн үйлдвэрүүдийг байршуулах төлөвлөгөө гарган ажиллах.

- Нийслэлийн Засаг даргын 2020 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн А/1081 тоот шийдвэрийг үндэслэн барилгын материалын бөөний болон жижиглэн худалдааны төв байгуулах 60 га газрын давхцалыг арилгуулан авсан.
- Төлөвлөлт хийх эхний ээлжийн ерөнхий төлөвлөгөө, судалгаа хийгдсэн бөгөөд Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газартай хамтран ТЭЗҮ, ХЕТ боловсруулах 201 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг татах ажлууд хийгдэж байна.

**ГУРАВ. " ТӨРИЙН ЖИНХЭНЭ АЛБАНЫ УДИРДАХ АЖИЛТНЫ МАНЛАЙЛЛЫН ЗОРИЛТ,
ХҮНИЙ НӨӨЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ" ЗОРИЛТЫГ
ХАНГАХАД ЧИГЛЭСЭН ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР**

3.1. “Байгууллагын үндсэн чиг үүргүүдийг амжилттай хэрэгжүүлэх үйл ажиллагааг манлайлан удирдана.” гэсэн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:

3.1.1. Үйлдвэрлэл, технологийн паркийн төслийн удирдлагын 9 чиг үүргийг мөрдөх.

- Инновацийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасан Паркийн удирдлагын чиг үүргийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг.

3.1.2. Байгууллагын стратеги төлөвлөгөөг тууштай хэрэгжүүлэхийг эрхэм зорилго болгон хамт олныг нэг чигт хөтлөх.

- Нийт ажилтан, албан хаагчдад болон шинээр орж буй ажилтнуудад байгууллагын эрхэм зорилго, бодлогын бичиг баримт, бизнес төлөвлөгөөг уншиж, ойлгосон байх үүрэг даалгавар өгч, байгууллагын эерэг соёлыг нэвтрүүлэх ажлуудыг авч хэрэгжүүлэн ажиллаж байна.

3.2. “Мэдлэг ур чадварыг дээшлүүлнэ.” гэсэн зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ:

3.2.1. Дотоод болон гадаадад удирдлагын менежментийн сургалтанд хамрагдах.

- Байгууллагын 2021 оны сургалт хөгжлийн төлөвлөгөөнд газрын удирдлагуудыг сургалтанд хамруулах талаар тусгасан.

3.2.2. Гадаад дотоодын ҮТП, чөлөөт бүсүүдийн олон улсын туршлага судлах, үйл ажиллагаатай танилцах.

- Гадаадын улс орнуудын үйлдвэрлэл технологийн нийт 67 паркийн жагсаалт гаргаж, үүнээс 18 паркийн ерөнхий үйл ажиллагаа, танилцуулгыг орчуулан бэлэн болгосон. Эдгээрээс Монгол улсын онцлогт тохирсон кластерийн бүтэцтэй, манай паркийн үйл ажиллагаатай төстэй үйлдвэрлэл технологийн паркийг сонгон авч танилцахаар мэдээлэл цуглуулан ажиллаж байна. Одоогоор дэлхийн хэмжээнд тархаад буй Ковид-19 цар тахлын улмаас Монгол улсад хилийн хориг тогтоосноос үүдэн биечлэн очиж туршлага судлах боломжгүй нөхцөл байдалтай байна.

3.3. “Хүний нөөцийг хөгжүүлэх, нийгмийн баталгааг хангах” гэсэн зорилтын хүрээнд чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ

3.3.1. Паркт ажиллах үйлдвэрүүдэд хүний нөөцийг бэлтгэх.

- Паркт үйл ажиллагаа явуулж буй үйлдвэрүүдийн ажиллах хүчний хэрэгцээний судалгааг гаргаж, сул орон тоо гарсан даруй Налайх дүүргийн хөдөлмөр, халамжийн хэлтэст, мэдээлэл хүргүүлэн, Налайх дүүргийн ажилгүй иргэдийг ажлын байраар хангаж

ажиллаж байна. 2021 оны байдлаар Налайх дүүргийн 82 иргэнийг тогтмол ажлын байраар хангаад байна.

3.3.2. Байгууллагын албан хаагчдын хүний нөөцийн сургалт, хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх.

- Холбогдох газруудаас зохион байгуулсан 10 сургалтад давхардсан тоогоор 29 албан хаагчийг цахимаар хамруулсан

3.3.3. Байгууллагын албан хаагчдыг чийрэгжүүлэх спорт арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх мөн ажилтан албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулах.

- Байгууллагын хэмжээнд “Гурван төрөлт”-ийн /даам, дартс, ширээний теннис/ тэмцээн зохион байгуулсан, Биеийн тамир, спортын хорооноос зохион байгуулсан “Цахим гимнастрада”-д ажлын байрны дасгалийн төрлөөр 8 албан хаагч оролцсон.
- Коронавирусын эсрэг дархлаажуулалтын 3 дахь тунд байгууллагын 14 албан хаагчаас 11 албан хаагч хамрагдсан. Коронавирусын ойрын хавьтлын шинжилгээг тухай бүр нь зохион байгуулж, хамруулсан.

3.3.4. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлын төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх.

- Жилийн эцсийн байдлаар 500,000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг ар гэрийн гачигдал гарсан 2 албан хаагчид олгосон ба Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын дагуу 6 албан хаагчид удаан жилийн нэмэгдэл олгосон.

3.3.5. Иргэдээс ирсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллах.

- Иргэдээс ирүүлсэн 4, албан хаагчдаас ирүүлсэн 14 өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж, тайлан мэдээг улирал бүр НЗДТГ-ын Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвд хүргүүлж байна.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 4 дүгээр хавсралт

ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН СУРГАЛТ, АЖИЛЛАХ НӨХЦӨЛ, НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ (..... он)

№	Үйл ажиллагаа	№	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин	Тайлбар
Хүний нөөцийг хөгжүүлэх, идэвхжүүлэх						
1.	Засгийн газар, төрийн байгууллага, бусад байгууллагаас албан хаагчдын мэдлэг, мэргэжлийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан дотоод сургалт	1.1.	Нийт сургалт, семинар, зөвлөгөөний тоо:	5	10	НЗДТГ-5, НАГ -1, НХААГ-1 НССТөв-1 сургалтад давхардсан тоогоор байгууллагын албан хаагчдыг 22 удаа сургалтанд хамруулав
		Үүнээс	Ажлын байран дахь сургалт	-	-	
			Мэргэшүүлэх сургалт	-	-	
			Туршлага солилцох арга хэмжээ	-	1	
			Бусад	-	9	
		1.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-	29	
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-	17	
			Эрэгтэй албан хаагч	-	12	
			Удирдах албан тушаалтан	-	2	
			Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-	27	
1.3.	Албан хаагчдыг сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	90-ээс дээш	Давхардсан тоогоор 29			
2.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр байгууллагын болон зохион байгуулагч талын зардлаар хамруулсан гадаад	2.1.	Нийт гадаад сургалт, семинар, зөвлөгөөний тоо	-		
		2.2.	Хамрагдсан нийт албан хаагчдын тоо:	-		
		Үүнээс	Эмэгтэй албан хаагч	-		
			Эрэгтэй албан хаагч	-		
			Удирдах албан тушаалтан	-		

	сургалт		Гүйцэтгэх, туслах албан тушаалтан	-		
		2.3.	Гадаад сургалтад хамруулсан байдал: Нийт албан хаагчдад эзлэх хувь	20-оос дээш		
3.	Албан хаагчдыг хөгжүүлэх, мэргэшүүлэх чиглэлээр зарцуулсан зардал, албан хаагчдын шилжилт хөдөлгөөн	3.1.	Албан хаагчдын сургалт, хөгжлийн үйл ажиллагаанд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	-		
		3.2.	Албан хаагчдын шилжилт хөдөлгөөний хувь	15-аас доош		
Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах						
4.	Цалин хөлс, шагнал, урамшууллын тогтолцоог хэрэгжүүлэх	4.1.	Цалин, шагнал, урамшуулалд зарцуулсан зардлын байгууллагын нийт төсөвт эзлэх хувь	-		Цалин, шагнал, урамшуулал нь жилийн нийт төсөвт эзлэх хувь 54 хувь. Жилийн эцсийн гүйцэтгэлээр 50 хувийг эзэж байна.
		4.2.	Нэгж албан хаагчид олгох хоол, унааны нэмэгдэл (мян.төг)	-		Ажилчдын хоол унааны зардалд өдрийн 10000 төгрөгийг тооцож олгодог. Жилийн эцсийн байдлаар 15,5 сая төгрөгийг олгосон.
5.	Албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөлийг бүрдүүлэх	5.1.	Ажлын байрны таатай орчны сэтгэл ханамжийн санал асуулгын дүн (Албан хаагчдын сэтгэл ханамж)	80-аас дээш		Байгууллагын албан хаагчдаас ажлын байрны сэтгэл ханамжийн 12 асуулга бүхий судалгаа авахад 86% буюу хангалттай гэж үнэлсэн байна.
6.	Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх	6.1.	Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг (Жилд)	1-ээс дээш		Цаг үеийн нөхцөл байдалтай холбогдуулан коронавирусын ойрын хавьтлын шинжилгээнд нийт албан хаагчдыг

						тухай бүр нь хамруулсан
		6.2.	Албан хаагчдын хамрагдалт	90-ээс дээш		
7.	Албан хаагчдыг нийгмийн баталгааг хангах чиглэлээр зарцуулсан зардал	7.1.	Албан хаагчдын нийгмийн асуудалд зарцуулсан зардлын хэмжээ (сая.төг)	-		2 албан хаагчид 500.0 төгрөгийн буцалтгүй тусламж олгосон ба Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгох журам”-ын дагуу 6 албан хаагчид удаан жилийн нэмэгдэл олгосон.

ДӨРӨВ. ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААР

- 4.1. Авилгын эсрэг, авилгаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа зохион байгуулах.
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 02 дугаар сарын 16-ны 03/726 тоот албан бичгийн хүрээнд 2021 оны 03 дугаар сарын 01-ний өдөр Авилгын эсрэг үйл ажиллагааны 2021 оны төлөвлөгөөг боловсруулж газрын даргаар батлуулан байгууллагын цахим хуудас болон вэб сайтад байршуулсан болно.
 - 2021.11.16-ний өдөр Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан “Авлигын шалтгаан, нөхцөл, хор уршиг”, “Ашиг сонирхлийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь”, “Авлигын гэмт хэргийн талаарх шинэ зохицуулалт, анхаарах асуудал” сэдэвт сургалтад байгууллагын нийт 6 албан хаагч хамрагдсан.
- 4.2. Архив, албан хэргийн хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологийн ололтыг нэвтрүүлэх, цахимжуулах ажлыг эрчимжүүлэх.
- Тоон гарын үсгийн системд бүрэн шилжсэн. Байгууллагын даргын 2020 оны 89 тушаалыг ERP Archive дэд цэсэд агуулга шивж оруулсан.
- 4.3. Албан хэрэг хөтлөлтийн Эдок системд албан хаагчид зөрчил үүсгэхгүй ажиллах.
- Байгууллагын албан хаагчдад Эдок дэд системийн боловсруулалт цэсийг ашиглан албан бичиг боловсруулах талаар заавар зөвлөмж хүргэж, системд зөрчилгүй ажиллахыг сануулсан. Жилийн эцсийн байдлаар хугацаа хэтэрч шилжүүлсэн 2, байгууллагын нэр буруу илгээсэн 1 зөрчилтэй байна.
- 4.4. Хэвлэмэл хуудасны ашиглалт, зарцуулалтад хяналт тавьж, буруутай этгээдэд хариуцлага ногдуулж ажиллах.
- Хэвлэмэл хуудасны ашиглалт зарцуулалтын мэдээг улирал бүр гарган, хагас бүтэн жилээр даргын тушаалаар үргүй зарцуулсан хэвлэмэл хуудсыг хүчингүй болгож байна.
- 4.5. Нийт албан хаагчид 2020 онд үүссэн архивын баримтыг ХХНЖ-ын дагуу архивт хүлээлгэн өгөх, үүссэн тусгай төрлийн баримтыг архивт хүлээлгэн өгөх.
- Архивын баримт хүлээн авах хуваарийн дагуу албан хаагчдаас цаасан суурьтай 88, цахим суурьтай 6 баримтыг хүлээн авч данс бүртгэлийг шинэчлэн гаргасан.
- 4.6. Байгууллагын Төсөв санхүүгийн үйл ажиллагааг төлөвлөх, үйл ажиллагааг хэвийн тасралтгүй явуулах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр өгөөжтэй, хэмнэлттэй зарцуулж өглөг авлагагүй ажиллах.
- Санхүүгийн тайлан мэдээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бүртгэж хөтлөх, санхүүгийн тайланг цаг хугацаанд нь бодитой тайлагнаж байгууллага үйл ажиллагаагаа хэвийн явуулах боломж нөхцөлөөр ханган Анхан шатны болон бусад баримтуудыг хууль тогтоомжийн дагуу бүрдүүлж, холбогдох тайланг бэлтгэн ажиллаж байна.
- 4.7. Байгууллагын өмч хөрөнгийн хадгалалт хамгаалалтад бүртгэлээр хяналт тавих.

- Байгууллагын өмч хөрөнгийг тооллогыг хагас жилийн эцсээр хийж ҮХ-58,2 сая, БМ-16,6 сая төгрөгийн хөрөнгийг бүрэн тооллоо. Хөрөнгийг бүрэн коджуулсан. Өмч хамгаалах комисс хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг бүрэн хариуцаж ажилладаг. Жилийн эцсийн тооллогыг 12 дугаар сард хийхээр төлөвлөөд байна.
- 4.8. МУ-ын Засгийн газрын 2020 оны 9-р тогтоолын дагуу “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого” зохион байгуулах.
- “Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого”-д бэлдэж бэлтгэл ажлын зохион байгуулж данс бүртгэлийг тулгаж баталгаажуулав.

НИЙСЛЭЛИЙН ТӨСӨВТ ТӨВЛӨРҮҮЛСЭН ОРЛОГО

Огноо	Төвлөрүүлсэн орлого /төгрөг/	Эх үүсвэр
2018	8,000,000	Сайханбаяр авлага
2019	99,000	Тендерийн баримт бичгийн орлого
2020	10,465,711 3,872,506.24 524,400 715,256	Усны төлбөр Усны төлбөр Цахилгааны төлбөр Ашиглалтын зардал
2021	10,298,000 2,000,000 12,176,000	“Пийс стийл групп” ХХК усны төлбөр Сайханбаяр авлага “Пийс стийл групп” ХХК усны төлбөр

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 5 дугаар хавсралт

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ, ШИЙДВЭРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ**

№	Зүйл заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц	Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6
1	Коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх, тархалтыг бууруулах зарим арга хэмжээ 2021.03.27-ны өдрийн А/221	<p>1. Нийслэлийн нутаг дэвсгэрт Коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх, тархалтыг бууруулах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийн халдварын тархалтын улбар шар түвшинд шилжсэн хугацааг 2021.04.05-ны 06 цаг хүртэл сунгасантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсүгэй.</p> <p>2. Байгууллагын үйл ажиллагааны хэвийн нөхцөл байдлыг алдагдуулахгүйгээр ажилтан албан хаагчид болон 0-12 насны хүүхэдтэй эх, өрх толгойлсон эцэг эхийг цахимаар ажиллах боломжоор хангахыг төрийн байгууллага, хуулийн этгээдийн удирдлагуудад зөвлөсүгэй.</p>	<p>Нийслэлийн Засаг даргын Коронавируст халдвар (Ковид-19)-аас сэргийлэх, тархалтыг бууруулах зарим арга хэмжээ 2021.03.27-ны өдрийн А/221 тоот захирамжийг үндэслэн газрын даргын 2021.04.02-ны өдрийн А/07 тоот тушаалаар Албан хаагчдыг цахимаар ажиллах тухай хуваарь баталсан.</p> <p>Нийт албан хаагчид дуудсан цагт бэлэн байж, холбоо барих утсаа нээлттэй байлган цахимаар албан үүргээ гүйцэтгэх хугацаанд байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр зохион байгуулахыг үүрэг болгосон .</p>		

2	<p>Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2021.04.09-ний А/265</p>	<p>1.Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын тархалтыг бууруулах зорилгоор улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан хязгаарлалт тогтоохгүй үйл ажиллагааны жагсаалтыг хавсралтаар баталсугай. 2. Хязгаарлалт тогтоохгүй төрийн байгууллага, хуулийн этгээдийн ажилтан албан хаагчдын 10 хүртэл хувийг ажлын үнэмлэх, албан байгууллагын тодорхойлолтыг үндэслэн хувийн болон албаны тээврийн хэрэгслээр хуанлийн өдрөөр автомашины улсын дугаарын сүүлчийн орон тэгш, сондгой тоогоор төгссөнөөр тодорхой маршрутын дагуу хязгаартайгаар замын хөдөлгөөнд оролцуулж, түгжрэл үүсэхгүй байх хариу арга хэмжээ авч ажиллах</p>	<p>Монгол улсын Засгийн газрын 2021 оны 91 дүгээр тогтоол, Нийслэлийн засаг даргын Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2021.04.09-ны А/265 тоот захирамжийг үндэслэн Газрын даргын 2021.04.12-ны А/08 тоот тушаалаар Албан хаагчдын цахимаар ажиллах хуваарийг шинэчлэн баталсан. Нийт албан хаагчид дуудсан цагт бэлэн байж, холбоо барих утсаа нээлттэй байлган цахимаар албан үүргээ гүйцэтгэх хугацаанд байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр зохион байгуулахыг үүрэг болгосон .</p>		
3	<p>Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2021.04.25-ны А/313</p>	<p>1.Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлын тархалтыг бууруулах зорилгоор улсын хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан хязгаарлалт тогтоохгүй үйл ажиллагааны жагсаалтыг хавсралтаар баталсугай. 2. Төрийн захиргааны болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын ажилтан албан хаагчдыг ажлын байранд ажиллуулахгүй байх, хуулийн этгээдийн үйл ажиллагааг тусгай горимд (уртасгасан, богиносгосон цаг, цахимаар, ээлжээр ажиллах) шилжүүлж зайлшгүй шаардлагаар биечлэн ажиллах албан хаагчдын тоог бууруулах зохион</p>	<p>Өмнө нь гаргасан Газрын даргын 2021.04.12-ны А/08 тоот тушаалаар Албан хаагчдын цахимаар ажиллах хуваарийг шинэчлэн баталсан. Нийт албан хаагчид дуудсан цагт бэлэн байж, холбоо барих утсаа нээлттэй байлган цахимаар албан үүргээ гүйцэтгэх хугацаанд байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүйгээр зохион байгуулахыг үүрэг болгосон .</p>		

		байгуулалтын арга хэмжээ авч ажиллуулахыг төрийн байгууллага, хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтнуудад үүрэг болгосугай.			
4	Нийслэлийн Онцгой комиссын хурлын тэмдэглэл 2021.11.15-ны өдөр	Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээний хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, Улсын онцгой комиссын ажлын хэсгийн хурлаас өгсөн үүргийг хэрэгжүүлэх хэрэгжүүлэх талаар	Нийслэлийн засаг даргын 2021 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн удирдах ажилтнуудын ээлжит шуурхай зөвлөгөөнөөр Онцгой комиссын даргын өгсөн үүргийн хүрээнд төрийн байгууллагын албан хаагчдыг дархлаажуулалтын нэмэлт тунд хамруулах, ажлыг эрчимжүүлж, хамрагдалтын тайлан мэдээг nokshuurhaishtab@gmail.com хаягаар хүргүүлсэн.		
5	Нийслэлийн Онцгой комиссын хурлын тэмдэглэл 2021.11.23-ны өдөр	Коронавируст халдвар (Ковид-19)-ын эсрэг дархлаа сэргээх нэмэлт тунгаар вакцинжуулах үйл ажиллагааг эрчимжүүлэх төлөвлөгөөний хэлэлцэж холбогдох асуудлаар үүрэг чиглэл өгсөн	Байгууллагын албан хаагчдад нэг өдрийн чөлөө олгож дархлаажуулалтын нэмэлт тунд хамруулах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Тайлан мэдээг 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн дотор nok@ulaanbaatar.mn хаягт хүргүүлнэ.		
6	Нийслэлийн Онцгой комиссын хурлын тэмдэглэл 2021.11.27-ны өдөр	Өмнөд Африкаас гаралтай Ковидын шинэ хувилбар Омикрон вируст халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, дархлаа сэргээх нэмэлт тунгийн вакцинжуулалтын талаар	ДЭМБ-аас Өмнөд Африкаас гаралтай шинэ хувилбарт Омикрон вирус дахин халдварлуулах эрсдэл өндөр байгааг анхааруулсантай холбогдуулан нийгмийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр эрсдлийг бууруулах, бэлэн байдлыг хангах хариу арга хэмжээг зохион байгуулсан ажиллаж байна.		
Хэсгийн дундаж: 100 хувь					
Нийт дундаж: 100 хувь					

ТАВ. ГАДААД ХАРИЛЦАА ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ЗОРИЛТЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

5.1. Англи хэлний сургалт авах.

- Байгууллагын албан хаагчдын Англи хэлний мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор мэргэжлийн байгууллагаар хэлний мэдлэгийн түвшинг тогтоолгох, түвшиндээ тохируулан сургалт авах сургалтын төвүүдийн судалгааг гаргаж, төсвийг гаргасан. Дэлхийн хэмжээнд тархаад буй Ковид-19 цар тахлын улмаас сургалтын байгууллагуудын үйл ажиллагааг хязгаарлаж, олон хүн нэг дор цугларахгүй байх үүднээс цахим хэлбэрээр түвшин тогтоолгох, сургалт авах боломжийг судлан гаргасан. Төсвийн асуудал шийдэгдмэгц сургалтыг эхлүүлэх бэлтгэл ажил бүрэн хангагдсан.

5.2. Байгууллагын мэдээлэл бүхий тараах материал, танилцуулгыг Англи, Солонгос, Хятад хэл дээр орчуулуулан бэлтгэх.

- Байгууллагын тараах материал, танилцуулгыг гадаадын хөрөнгө оруулагчдад танилцуулах зорилгоор Англи болон Солонгос хэл рүү орчуулан бэлтгэсэн. Хятад хэл рүү орчуулуулах мэргэжлийн байгууллагын судалгааг гаргасан. Төсвийн асуудал шийдэгдвэл орчуулуулах бэлтгэл ажил бүрэн хангагдсан.

5.3. Гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдад, иргэд аж ахуйн нэгжүүдэд паркийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл, Паркийн танилцуулга материал, товхимлуудыг түгээж, уулзалт зөвлөгөөн зохион байгуулах.

- 2021 оны эхэнд тухайн жилд олон улсад зохион байгуулагдах барилгын салбарын үзэсгэлэн яармаг, хурал, зөвлөгөөний мэдээллийг нэгтгэн гаргасан боловч дэлхий дахинд тархаад буй COVID 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд Монгол улсад хилийн хориг тавьсантай холбоотойгоор оролцох боломжгүй байдал үүссэн.
- 2021 оны 02 дугаар сарын 06-ны өдөр БХБЯамны албаны хүмүүстэй уулзалт зохион байгуулсан. Уулзалтаар Паркийн цэвэрлэх байгууламж, дулаан хангамж, усан хангамж, инженерийн шугам сүлжээ зэрэг дэд бүтцийн ажлуудад шаардагдах хөрөнгө оруулалтын, хүчин чадлын мэдээллийг танилцуулж, хөрөнгө оруулалтын ажлуудыг хамтран зохион байгуулж, БХБЯамнаас дэмжин ажиллахаа мэдэгдсэн.
- БХБЯам болон “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төсөлтэй хамтран Европын Хөрөнгө Оруулалтын Банкны зээлээр паркийн Цэвэрлэх байгууламж, Дулааны станц, Инженерийн шугам сүлжээ зэрэг дэд бүтцийн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэхээр 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдөр уулзалт зохион байгуулсан.
- 2021 оны 4 дүгээр сарын 19-нд Үндэсний Хөгжлийн Газар болон Монгол залуусын үүсгэн байгуулсан Сингапур улсад төвтэй Irbis Ventures компанитай хамтран зарласан “Төсөл чадавхижуулах хөтөлбөр”-т хамрагдсан. Уг хөтөлбөр нь хөрөнгө оруулалтын бодлого,

зохицуулалтыг хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд хувийн хэвшил болон хөрөнгө оруулалт шаардлагатай аж ахуйн нэгжүүдийн хэрэгжүүлж буй, олон улсаас хөрөнгө оруулалт татах боломжтой төслүүдийн бэлэн байдлыг ханган, хөрөнгө оруулагчдад танилцуулах, улмаар хөрөнгө оруулалт татахад үндэсний компаниуд, тэдгээрийн үүсгэн байгуулагч нарт дэмжлэг үзүүлэх зорилготой. Тус хөтөлбөрт НБМҮТ Паркийн төслийн материалыг Англи Монгол хэл дээр хүргүүлсэн. Хөтөлбөрт хамрагдсан нийт төслүүдэд Төсөл чадавхижуулах хөтөлбөрийн сургалтуудыг явуулсан ба нийт 6 удаагийн цахим сургалтанд хамрагдсан. Сургалтанд хамрагдсанаар төслийн танилцуулгаа илүү сайжруулж олон улсад хүлээн зөвшөөрөгдөхүйц төслийг боловсруулах бүрэн боломжтой болсон.

5.4. Гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд чиглэсэн улсын байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, арга хэмжээнүүдийг төлөвлөх, зохион байгуулах.



- Гадаадын үйлдвэрлэл технологийн 67 паркийн жагсаалт, Олон улсын хамтын ажиллагаа, хөрөнгө оруулагч донор 108 байгууллагын жагсаалт гарган судалгааны ажлыг явуулж байна. Нийт 108 байгууллагаас 48, 67 паркаас 11 паркийн ерөнхий мэдээллийг орчуулан 5 төрлийн шалгуур үзүүлэлтээр хүснэгт гарган харьцуулалт хийж байна.
- Паркад байршихаар гэрээ хийгдсэн үйлдвэрүүд болон хүсэлт ирүүлсэн үйлдвэрүүдэд Дүүргийн ЗДТГ-тай хамтран Паркийн танилцуулга, үйл ажиллагаа, хамтран ажиллах боломжуудын талаар мэдээлэл өгөх зорилготой уулзалт зөвлөгөөнийг зохион байгуулахаар төлөвлөсөн боловч Дэлхийн хэмжээнд тархаад буй Ковид-19 цар тахлын улмаас хойшлогдсон байдалтай байна.

5.5. Паркийн 120 га талбайн Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, Мастер төлөвлөгөөг бүрэн эхээр нь Англи хэл рүү мэргэжлийн байгууллагаар хөрвүүлүүлж бэлтгэх.

- Гадаадын хөрөнгө оруулалт татахын тулд паркийн баримт бичгийг Англи хэл дээр бүрэн бэлтгэх хэрэгтэй бөгөөд үүнд Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, Мастер төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар хөрвүүлүүлэх бэлтгэл ажил бүрэн хийгдсэн. Англи хэл рүү орчуулах мэргэжлийн байгууллагын судалгааг гаргаж төсвийг танилцуулсан бөгөөд төсвийн асуудал шийдэгдмэгц баталгаат орчуулга хийгдэхээр бэлтгэл ажил хангагдсан байна.

ЗУРГАА. "МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ" ЗОРИЛТЫГ ХАНГАХАД ЧИГЛЭСЭН ХӨТӨЛБӨР, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТАЛААР

- 6.1. Мэдээллийн ил тод байдлыг хангах, байгууллагын сайт, цахим хуудаснуудад үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг тогтмол тавьж байх /Паркийн болон Худалдааны төвийн/.
- Тус байгууллага нь Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу байгууллагын вэб сайт, пэйж хуудас болон мэдээллийн самбараар дамжуулан:
 - Үйл ажиллагааны ил тод байдал
 - Хүний нөөцийн ил тод байдал
 - Төсөв, санхүүгийн ил тод байдал
 - Худалдан авах ажиллагааны ил тод байдал гэсэн дөрвөн төрлөөр мэдээ мэдээллүүдийг тогтмол болон цаг тухай бүрт нь мэдээлэн ажиллаж байна.
 - 2021 оны байдлаар үйл ажиллагаатай холбоотой шинэ мэдээ мэдээлэл - 6, сул орон тооны зар - 1, төсөв санхүүгийн ил тод байдалтай холбоотой мэдээлэл – 6 тавигдаж, шинэчлэгдсэн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн журам байршуулсан. Мөн CoVid 19 цар тахлаас урьдчилан сэргийлэхтэй холбоотойгоор холбогдох байгууллагаас гарч байгаа зөвлөмж, мэдээллийг байгууллагын вэб хуудсаар тогтмол мэдээлж ажиллаж байна.
- 6.2. Мэргэжлийн холбоод, судалгаа шинжилгээний байгууллагуудтай хамтран хурал, зөвлөгөөн зохион байгуулж, судалгаа хийх.
- 2021.02.04-ний өдөр Паркийн дарга С.Батжаргал болон Ахлах мэргэжилтэн Н.Пүрэвсүрэн, Цахилгааны инженер Б.Гансүх нар Паркийн үндсэн цахилгаан хангамжийн бүтээн байгуулалтын гүйцэтгэгч компаниуд болох “Хасу Эрчим” ХХК, “Виллвест” ХХК нарын удирдлагуудын хамт Нийслэлийн Инноваци, технологийн асуудал хариуцсан төслүүдийн удирдагч Д.Ихбаяртай уулзалт зохион байгууллаа. Тус уулзалтаар Паркийн цахилгаан хангамжийн бүтээн байгуулалтын ажлын явцын талаар мэдээлэл солилцсон 2021 онд хийгдэх ажлууд, цаашдын эх үүсвэр хаанаас орж ирэх тухай хэлэлцсэн. Уулзалтын төгсгөлд Д.Ихбаяр дарга Паркийн үйл ажиллагаа, бүтээн байгуулалтыг бүх талаар дэмжиж ажиллахаа илэрхийлсэн байна.




- 2021 оны 02 дугаар сарын 10-ны өдөр Барилга хот байгуулалтын яамны Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Г.Цогтсайхан, “Улаанбаатар хотын гэр хорооллыг хөгжүүлэх хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр” төслийн зохицуулагч Д.Авирмэд, уг төслийн Ерөнхий инженер н.Жанлавцогзол, Дулааны инженер н.Цолмон, Налайхын барилгын материалын үйлдвэрлэл, технологийн паркийн Дарга С.Батжаргал, Ахлах мэргэжилтэн Н.Пүрэвсүрэн, Инженер Б.Гансүх зэрэг бүрэлдэхүүнтэйгээр 4 дэх уулзалтаа зохион байгууллаа. Парктай хамтран ажиллах гэрээ байгуулсан үйлдвэрүүдийн бүтээн байгуулалт эхэлж, үйл ажиллагаагаа явуулахад хамгийн түрүүнд нэн шаардлагатай байгаа 1000м³/хоногийн хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийг барьж байгуулах асуудлыг нэгт тавин ажиллаж байгаа бөгөөд үүний араас 26МВт-ын хүчин чадалтай дулааны станц, Паркийн олон нийтийн барилга байгууламж болон 50 үйлдвэрийг хангах инженерийн шугам сүлжээ, цэвэр усны 400м³-ийн 2 усан сан, техник болон галын 200м³ 2 усан сан бүхий усан хангамж зэрэг дэд бүтцийн хөрөнгө оруулалтын асуудлыг цогцоор нь шийдвэрлэхээр зорьж ажиллаж байна.



- 2021 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газраас Нийслэлийн Үйлдвэрлэл, технологийн паркуудын өнөөгийн байдал цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаарх цахим уулзалтыг Хүнс, Хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Барилга хот байгуулалтын яам, Зам тээврийн хөгжлийн яам, Эрчим хүчний яам, Уул уурхай хүнд үйлдвэрийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Үйлдвэрлэл технологийн паркуудтай хамтран зохион байгууллаа. Уулзалтаар Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газрын дарга Л.Тулгабаатар Нийслэлийн Үйлдвэрлэл, технологийн паркуудыг байгуулах ажлын явцын талаар болон Үйлдвэрлэл технологийн паркуудыг байгуулахтай холбоотой бодлогын баримт бичгүүдийг танилцууллаа.

Тус уулзалтаар талууд паркуудын ТЭЗҮ-г шинэчлэн сайжруулах, паркуудын үйл ажиллагааны чиглэлийг тодорхой болгох, ҮТПаркийн эрх зүйн орчин болон төр хувийн хэвшлийн түншлэлийн орчныг сайжруулах талаар санал солилцоо.

Цаашид Үйлдвэрлэл технологийн паркийг хөгжүүлэх талаар яамдуудаас төлөөлөл оролцуулсан ажлын хэсэг байгуулж, төлөвлөгөө гаргаж ажиллахаар боллоо.



- 2021 оны 08 дугаар сарын 18-ны өдөр Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газрын харъяа 4 аж үйлдвэрийн паркийн үйл ажиллагааны чиглэлийг шинэчлэн тодорхойлох, паркуудын хөрөнгө оруулалтын ажлуудыг эрэмбэлэх, эрчимжүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх үүрэг бүхий ажлын хэсэг уг асуудал дээр байр сууриа илэрхийлж, санал солилцон ажиллалаа. Хэлэлцүүлгийг Нийслэлийн Шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газар зохион байгуулж, тус газрын дарга Л.Тулгабаатар үйлдвэрлэл, технологийн паркуудын өнөөгийн нөхцөл байдлын талаар танилцуулсан юм.

Мэргэжлийн холбоодыг төлөөлж:

- Монголын хог хаягдлыг дахин боловсруулах үндэсний холбооны гүйцэтгэх захирал Д.Батжаргал;
- Монголын ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн холбооны менежер Н.Энхсайхан;
- Монголын сав баглаа боодол үйлдвэрлэгчдийн нэгдсэн холбооны тэргүүн Б.Болдбаатар;
- Оёдлын салбарын нэгдсэн мэргэжлийн холбооны гүйцэтгэх захирал О.Саранхүү;
- Эм зүй байгууллагуудын ЭМ холбооны менежер Н.Буянчимэг;
- Монголын сүүний нэгдсэн холбооны тэргүүн Н.Ганхуяг;
- Монголын сүүний нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал Б.Жадамбаа;
- Монголын барилгын материал үйлдвэрлэгчдийн холбооны зөвлөх Р.Бямбажав нар оролцлоо.

Хэлэлцүүлгийн үр дүнд холбоодын удирдлагууд үнэтэй саналыг тусгаж байлаа. Уг тусгасан саналуудыг нэгтгэж, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах юм.



- 2021 оны 08 дугаар сарын 31-ны өдөр НБМҮТТПарктай гэрээ байгуулан үйлдвэрлэлийн барилга байгууламжийн ажлаа эхлүүлэхээр бэлтгэл ажлаа бүрэн хангаад буй “Монгол Авто Ресайкл Парк” ХХК-ийн БНСУ-ын хөрөнгө оруулагч нарын хүсэлтийн дагуу Паркийн дарга болон инженер, мэргэжилтнүүдтэй уулзалт зөвлөгөөн зохион байгууллаа. “Монгол Авто Ресайкл Парк” ХХК нь БНСУ-ын Ресайкл Парк ХК-ийн 100хувийн хөрөнгө оруулалтаар байгуулагдсан компани бөгөөд КОЙКА олон улсын байгууллагатай хамтран тус паркад төсөл хэрэгжүүлэхээр гэрээ байгуулан ажиллаж байна. Тус компани нь БНСУ-ын “Ресайкл Парк” ХК-ийн технологи, системээр автомашин, тээврийн хэрэгслийг задлах дахин боловсруулах систем, тогтолцоог бий болгож, ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийг дахин боловсруулах, нөөцийг эргүүлэн ашиглах технологийг Монгол улсад нэвтрүүлэхийг зорилго болгон ажиллаж байгаа юм. Эхний ээлжийн барилга байгууламж баригдсанаар нийт 50 гаруй ажлын байр бий болно. Уулзалтаар Паркийн зүгээс ажлаа хурдан эхлүүлэхийг хэлж бидний зүгээс бүх талын туслалцаа дэмжлэгийг үзүүлэхээ илэрхийллээ.



- 2021 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газраас Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хуулийн хэрэгжилтэд үнэлгээ хийх, мэдээлэл цуглуулах зорилгоор Налайхын Барилгын Материалын Үйлдвэрлэл, Технологийн Паркийн үйл ажиллагаатай танилцаж, үнэлгээний ажилд шаардлагатай мэдээллийг цуглуулах ажил зохион байгуулагдлаа. Уг ажлыг Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн зөвлөхийн

үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Нандингэрэлээр ахлуулсан, Реферэнт Ц.Элбэгзаяа, Б.Энхмаа нарын бүрэлдэхүүнтэй баг ирж,

- Үйлдвэрлэл, технологийн паркийн эрхзүйн байдлын тухай хуулийн хэрэгжилт, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцох,

- Төрөөс паркийн үйл ажиллагааг дэмжих чиглэлээр үзүүлж байгаа хөнгөлөлт, дэмжлэг оновчтой болсон эсэх талаар мэдээлэл авах,

- Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсэн дэд бүтэц, санхүүжилтийн үр нөлөөний талаар мэдээлэл цуглуулах,

- Хууль хэрэгжүүлэхэд үүсч байгаа дэвшилттэй тал болон, тулгарч байгаа хүндрэл бэрхшээл, түүний шалтгаан нөхцлийг тодорхойлох зэрэг үндсэн чиглэлүүдээр санал солилцож, ажиллалаа.



- 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдөр НИТХурлын төлөөлөгч, Хот байгуулалт, дэд бүтцийн хорооны дарга М.Говьсайхан, НИТХурлын тэргүүлэгч, хурлын Байгаль орчин, ногоон байгууламжийн хорооны гишүүн Д.Гантулга, НИТХурлын төлөөлөгч, Засаглал, эрхзүйн шинэтгэлийн хорооны гишүүн Д.Ихбаяр, НИТХурлын даргын зөвлөх Ш.Үнэнбат, Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны дарга А.Энхманлай, Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газрын дарга Ц.Тулга, НЗДТГазрын Хууль, эрхзүйн хэлтсийн дарга Б.Мөнгөншагай, НБМҮТП ОНӨААТҮГазрын дарга С.Батжаргал, НИТХурлын төлөөлөгч, Налайх дүүргийн Засаг дарга Ч.Раднаабазар, Налайх дүүргийн Засаг даргын орлогч С.Тунгалаг, НИТХурлын Ажлын албаны Хууль эрхзүй, хяналт үнэлгээний хэлтсийн дарга А.Анхбаяр нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг Налайхын Барилгын Материалын Үйлдвэрлэл, Технологийн Парк дээр ирж ажиллалаа. Мөн уулзалтанд тэсрэх бодисны үйлдвэрийн төлөөлөл болох Нитро Сибирь-Монголиа ХХК, Мера ХХК, Илч түлш ХХК-ийн холбогдох албан тушаалтнууд ирж оролцсон.

Уг уулзалтаар:

- НБМҮТПаркийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө болон Нийслэлийн хэмжээнд тэсэрч дэлбэрэх бодисын үйлдвэр, агуулахын үйл ажиллагааг төвлөрүүлэхээр төлөвлөгдсөн байршлийн талаар,

- Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрийн болон хадгалах байр, агуулахын аюулгүйн бүс нь Паркийн болон бусад байгууллагын эзэмшлийн газартай давхацсан эсэх талаарх мэдээлэл,

- Налайх дүүрэгт арматур төмрийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа явуулагч “Эйч Ди Ти Эм” ХХК-ийн талаар тус тус хэлэлцлээ.

“Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөний тодотгол, 2030 он хүртэлх хөгжлийн чиг хандлага”, “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг, “Багахангай дүүргийн хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө” зэрэгт тэсрэх бодисын агуулах нь Багахангай дүүргийн 2-р хороонд байршихаар тусгагдсан бөгөөд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Зам, тээврийн хөгжлийн яам болон дээрх ажлын хэсэг тус тусын саналаа боловсруулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнд хүргүүлэхээр болов.



- 2021 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Хөгжлийн бодлого хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэн, НИТХурлын төлөөлөгч, Хот байгуулалт, дэд бүтцийн хорооны дарга М.Говьсайхан, НИТХурлын төлөөлөгч, Засаглал, эрхзүйн шинэтгэлийн хорооны гишүүн Д.Ихбаяр, НИТХурлын Тэргүүлэгч Б.Нэргүй, НДЗД Ч.Раднаабазар, БҮТГ-ийн дарга Ч.Элбэгсайхан, БХҮТГ-ийн дарга Ц.Жамбалцэрэн нар үйлдвэрлэл технологийн паркуудын үйл ажиллагаатай танилцаж, хөрөнгө оруулалтын талаар мэдээлэл солилцлоо. Паркуудын зүгээс 2022 оны Нийслэлийн төсвөөс хөрөнгө оруулалт шаардлагатай байгаа төслүүдээ танилцуулсан бөгөд паркуудын бүтээн байгуулалтын ажлыг бүх талаар дэмжиж ажиллахаа илэрхийллээ



- 6.3. Барилгын материалын салбарынханд чиглэсэн уулзалт, хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн яармаг гэх мэт арга хэмжээнүүдэд идэвхтэй оролцоно.
- 2021 онд зохиогдох барилгын салбарын үзэсгэлэн яармаг, хурал зөвлөгөөний мэдээллийг нэгтгэн гаргасан бөгөөд эхний хагас жилд CoVid 19 цар тахлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээнээс болж, үзэсгэлэнгүүд цуцлагдсан байдалтай байна.
- 6.4. Хэвлэл, мэдээллийн хэрэгсэлтэй хамтран ажиллах, ҮТП-н талаар ярилцлага хүргэх.
- 2021 оны байдлаар Налайх ТВ, МҮОНРТ, Eagle ТВ-ээр паркийн тухай мэдээлэл, сурвалжлага гарсан байна.
- 6.5. Барилгын материалын бөөний болон жижиглэнгийн худалдааны төвийн танилцуулга, сурталчилгааг видео болон хэвлэмэл хэлбэрээр гаргах.
- Худалдааны төвийн Хэсэгчилсэн Ерөнхий Төлөвлөгөө боловсруулах ажлын төсвийг гаргаж, уг ажилд шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах ажлыг зохион байгуулж ажиллаж байна.
- 6.6. Бөөний болон жижиглэнгийн худалдааны төвийг Төр хувийн хэвшлийн түншлэлээр байгуулахтай холбогдуулан хөрөнгө оруулагч байгууллагуудтай уулзалт зохион байгуулах.
- Худалдааны төвийн Хэсэгчилсэн Ерөнхий Төлөвлөгөө боловсруулах ажлын төсвийг гаргаж, уг ажилд шаардлагатай хөрөнгө оруулалтыг татах ажлыг зохион байгуулж ажиллаж байна. Хөрөнгө оруулалт татах ажлын хүрээнд холбогдох яамдуудад хамтран ажиллахыг хүссэн албан бичиг хүргүүлээд байна.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 9 дүгээр хавсралт

ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ТАЙЛАГНАХ ХҮСНЭГТ

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Байгууллагын веб сайт, фейсбүүк хуудас болон мэдээллийн самбарт тогтмол байршуулдаг.	100%
2.	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Байгууллагын веб сайт, фейсбүүк хуудас болон мэдээллийн самбарт тогтмол байршуулдаг.	100%
3.	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Одоогоор үйлчилгээ үзүүлээгүй төслийн шатандаа явагдаж байгаа ба сонирхсон аж ахуйн нэгж хувь хүмүүст шаардлагатай мэдээллийг тухай бүр гарган өгч байгаа.	100%
4.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Байгууллагын веб сайт, фейсбүүк хуудас болон мэдээллийн самбарт тогтмол байршуулдаг.	100%
5.	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсанд 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;	Шинээр боловсруулж буй бодлогын бичиг баримтыг цахим хуудсанд байршуулдаггүй ба батлагдсан бодлогын бичиг баримтыг тогтмол байршуулдаг.	100%

6.	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	Одоогоор үйлчилгээ үзүүлээгүй төслийн шатандаа явж байна	100%
7.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;	Төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлж байгаа ажил байхгүй болно.	100%
8.	Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Зөвшөөрөл олгодоггүй.	100%
9.	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх;	Бүтээн байгуулалт болон зураг төслийн ажлын талаарх мэдээллийг тухай бүрт нь байршуулдаг.	100%
Хэсгийн дундаж хувь:			100%
Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал;			
1.	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;	2021 оны байдлаар нийт 3 ажлын байр зарлагдаж, зарыг байршуулсан ба парк үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн хүний нөөцийн бүрдүүлэх үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлж байна.	100%

2.	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Ажлын байрны цаг ашиглалт, сахилга, дэг журмыг сайжруулах ёс зүйн хороо байгууллагын даргын 2018 оны 1 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 тоот тушаалын дагуу ажиллаж байна.	100%
3.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Нийгмийн баталгааг хангах, байгууллагын албан хаагчдын сургалт хөгжлийн төлөвлөгөөг цахим хуудаснуудад байршуулан ажиллаж байна.	100%
4.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	Хүний нөөцийн чиглэлийн үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг тухай бүрт байршуулдаг.	100%
5.	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	Газрын даргын 2017 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн А/13 тоот тушаалаар "Ажилтан албан хаагчдын ажлыг үнэлж, дүгнэх үр чадварын нэмэгдэл олгох журам"-ыг батлан байгууллагын үйл ажиллагааны үр дүн, гүйцэтгэлийг үнэлэн ажиллаж байна.	100%
Хэсгийн дундаж хувь:			100%
Хэрэгжилтийн дундаж хувь:			100%

ЗӨВШӨӨРСӨН: ХОТ


НБМҮТП ОНӨТҮГ-ЫН ДАРГА

ХЯНАСАН


АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ТӨЛӨВЛӨЛТ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН



С.БАТЖАРГАЛ



Н.ПҮРЭВСҮРЭН



Н.ГАНТУЛГА

